



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2025.08.28 № 1 / 3252

танай _____ -ны № _____ -т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Таны 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/9628 дугаар албан бичигтэй танилцлаа.

Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн үйлчилгээг зохицуулж буй холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2024 онд 873, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 613 (хянагдаж байгаа 51) өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд тус тус хянан шийдвэрлэсэн.

Дээрх өргөдөл, гомдлоос 2024 онд 55.06%, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 48.12% нь даатгалын үйл ажиллагаатай холбогдох асуудалд хамаарах буюу нийтлэг өргөдөл, гомдлын агуулгын хувьд даатгагч болон даатгуулагчийн хооронд бий болсон авто тээврийн хэрэгслийн, эсхүл жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний маргаантай холбогдож байна.

2024 он, 2025 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 8... хуудастай.


Хүндэтгэсэн,

ДАРГА



Г.ЖАМБААЖАМЦ

1512005924



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**2024-2025 ОНЫ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хороо 2024 оноос 2025 оны хагас жилийн байдлаар нийт 1486 өргөдөл, гомдол хүлээн авснаас албан бичгээр хандсан 1134, цахим системээр хандсан 250, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 102 өргөдөл, гомдол ирүүлсэн байна.

Хүснэгт 1. Нийт өргөдөл гомдлын тоо (салбараар)

№	Салбар	2024 он					2025 оны хагас жил				
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Даатгалын зах зээл	385	71	16	472	54.06%	162	90	43	295	48.12%
2	Үнэт цаасны зах зээл	134	0	3	137	15.70%	60	4	16	80	13.05%
3	Банк бус санхүүгийн байгууллага	112	21	7	140	16.04%	92	30	5	127	20.72%
4	Хадгаламж, зээлийн хоршоо	29	-	-	29	3.32%	25	-	-	25	4.08%
5	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа	19	4	2	25	2.86%	26	4	1	31	5.08%
6	Бусад	47	19	4	70	8.02%	43	7	5	55	8.95%
	Нийт	726	115	32	873	100%	408	135	70	613	100%

Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон ХК-тай холбоотой нийт 217 өргөдөл, гомдол ирүүлсэн.

Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2024 он					2025 оны хагас жил				
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	29	-	-	29	21.17%	12	1	1	14	18%
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээллийг шалгуулах	22	-	-	22	16.06%	2	-	3	5	6%
3	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	-	-	3	3	2.19%	2	-	-	2	3%
4	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	16	-	-	16	11.7%	3	2	-	5	6%

2024-2025 оны өргөдөл, гомдлын судалгааны тайлан

5	Тохиромжтой этгээдийн тодорхойлолт	16	-	-	16	11.7%	11	-	-	11	14%
6	Үнэт цаасны харилцагчийн эрх ашиг хөндөгдсөн талаар	4	-	-	4	2.9%	21	1	-	22	28%
7	Ногдол ашиг тараах	1	-	-	1	0.73%	1	-	12	13	16%
8	Зөрчилтэй холбоотой	12	-	-	12	8.75%	3	-	-	3	4%
9	Хөрөнгө оруулалтын сантай холбоотой	7	-	-	7	5.10%	-	-	-	-	-
10	Бусад	27	-	-	27	19.70%	5	-	-	5	5%
Нийт		134	-	3	137	100%	60	4	16	80	100%

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, үнэт цаасны компаниудаас баримт, тайлбар гаргуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэж байна.

Тайлант хугацаанд үнэт цаастай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлуудаас хувьцааны бүртгэл данс шалгуулах тухай, хувьцааг харилцагчийн зөвшөөрөлгүй арилжсан тухай болон үнэт цаасны компани, хувьцаат компанийн үйл ажиллагаатай холбогдох өргөдлийн тоо өндөр байгаа нь хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, ягаан, цэнхэр тасалбартай холбоотой мэдээллийг шалгуулах, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д харилцагчдын их хэмжээний мөнгө тараагдаагүй төвлөрч байгаатай холбоотой байна.

Даатгалын зах зээл

Тайлант хугацаанд даатгалын үйлчилгээтэй холбоотой нийт 767 өргөдөл, гомдлыг ирүүлсэн байна.

Хүснэгт 3. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2024 он					2025 оны хагас жил				
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	244	40	5	289	61.22%	94	24	3	121	41%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	71	21	3	95	20.12%	42	52	13	107	36%
3	Нөхөн төлбөрийг	35	7	-	42	8.89%	11	2	-	13	4.0%

2024-2025 оны өргөдөл, гомдлын судалгааны тайлан

	хасаж олгосон											
4	Даатгалын хураамжийн маргаан	3	1	1	5	1.05%	2	2	22	26	9%	
5	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	21	2	5	28	5.97%	9	13	3	25	8%	
6	Даатгалын үйл ажиллагаа	11	-	2	13	2.75%	1	1	1	3	1%	
	Нийт	385	71	16	472	100%	159	94	42	295	295	

Хүснэгт 4.Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл

№	Даатгалын төрөл	2024 он					2025 оны хагас жил				
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Жолоочийн хариуцлагын даатгал	60	13	4	77	16.31%	20	10	25	55	19%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	215	49	10	274	58.05%	120	71	15	206	70%
3	Гэнэтийн ослын даатгал	39	5	-	44	9.32%	7	1	-	8	3%
4	Хөрөнгийн даатгал (ипо тек)	28	-	-	28	5.93%	7	3	-	10	3%
5	Хариуцлагын даатгал	3	1	1	5	1.05%	1	-	-	1	0%
6	Зээлийн даатгал	8	1	-	9	1.90%	1	-	-	1	0%
7	Санхүүгийн даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	0.0%
8	Ачааны даатгал	2	-	-	2	0.46%	2	-	-	2	1.0%
9	Гэрлэлтийн даатгал	5	-	-	5	1.05%	2	-	-	2	1.0%

2024-2025 оны өргөдөл, гомдлын судалгааны тайлан

10	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	25	2	1	28	5.93%	3	3	4	10	3%
	Нийт	385	71	16	472	100%	163	88	44	295	100%

Ирсэн өргөдөл, гомдлын агуулгаас үзэхэд даатгуулагч даатгалын тохиолдол гарсан үед тухайн тохиолдлыг нотлох, даатгагч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг үүргээ биелүүлээгүй, даатгалын хураамжийг хуваарьт хугацаанд төлөөгүй зэргээс шалтгаалж даатгалын нөхөн төлбөр авах боломжгүй байдал үүсдэг байна.

Мөн даатгагчаас даатгуулагчид бүтээгдэхүүний талаар танилцуулга хийгээгүй, гэрээнд даатгалын зүйлийн мэдээллийг буруу оруулах, гэрээнд нөхөн төлбөр олгохоор заасан нөхцөл байдал үүссэн байхад илт үндэслэлгүйгээр татгалзах, нөхөн төлбөр олгохгүй удаах, үндэслэлгүйгээр нөхөн төлбөрийг хасаж олгосон, гэрээнд заагаагүй аливаа шаардлага, хязгаарлалт тавих зэрэг асуудлаар өргөдөл, гомдол гаргасан байна.

2024 онд харилцагчийн хохирол барагдуулах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан 203 иргэн, хуулийн этгээдэд 4,349,569,310.86 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 90 иргэн, хуулийн этгээдэд 1,200,951,779.92 төгрөгийн нөхөн төлбөрийг, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 89 иргэн, хуулийн этгээдэд 1,256,307,662 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 43 иргэн, хуулийн этгээдэд 292,236,241 төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон байна. Нөхөн төлбөр олгоогүй байгаа маргааны хувьд талууд шүүхээр маргаанаа эцэслэн шийдвэрлүүлэх ажиллагаа явагдаж байгаатай холбоотой байна.

Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 267 өргөдөл, гомдол ирүүлсэн байна.

Хүснэгт 5. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2024 он					2025 оны хагас жил				
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл	44	5	-	49	35%	39	12	2	53	42%
2	Зээл болон хүүгийн тооцоолол	7	4	-	11	7.85%	10	1	3	14	11%
3	Барьцааны зүйл чөлөөлүүлэх	2	-	2	4	2.5%	4	2	-	6	5%
4	Зээлийн гэрээний маргаан	13	3	-	16	11.7%	12	1	-	13	10%

2024-2025 оны өргөдөл, гомдлын судалгааны тайлан

5	ББСБ-ын үйл ажиллагаа	30	5	5	40	28.58%	17	9	-	26	20%
6	Лавлагаа	1	-	-	1	0.79%	6	-	-	6	5%
7	Бусад	15	4	-	19	13.58%	4	5	-	9	7%
	Нийт	112	21	7	140	100%	92	30	5	127	100%

Ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх хувийг зээлийн мэдээллийн сантай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна. Уг гомдлын хувьд иргэд зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн, зээлийн төлөлт хойшлуулах хүсэлтээ тухайн банк бус санхүүгийн байгууллагад албан ёсоор хүргүүлээгүйн улмаас маргаан үүсэх, улмаар зээлийн мэдээллийн сан дахь зээлийн ангилал буурч бүртгэгдсэнтэй холбоотой байна.

Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбогдуулан нийт 54 өргөдөл, гомдлыг ирүүлсэн байна.

Хүснэгт 6. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2024 он					2025 оны хагас жил				
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Лавлагаа гаргуулах	15	-	-	15	51.7%	18	-	-	18	72%
2	Хадгаламж буцаан олгоогүй	-	-	-	-	-	-	-	-	-	0.0%
3	ХЗХ-дын үйл ажиллагаа	11	-	-	11	37.9%	6	-	-	6	24%
4	Бусад	3	-	-	3	10.4%	1	-	-	1	4%
	Нийт	29	-	-	29	100%	25	-	-	25	100%

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдуулан нийт 55 өргөдөл, гомдлыг ирүүлсэн байна.

Хүснэгт 7. Мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2024 он					2025 оны хагас жил				
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь

2024-2025 оны өргөдөл, гомдлын судалгааны тайлан

1	Өндөр хүүтэй зээл олгох	4	2	1	7	29.18%	6	2	1	9	29%
2	Алданги, хүү буруу тооцох	6	2	1	9	37.5%	2	-	-	2	6%
3	Зээлийн барьцааг борлуулах	1	-	-	1	4.16%	3	1	-	4	13%
5	Зээлийн эргэн төлөлт шалгуулах	3	-	-	3	12.5%	4	-	-	4	13%
6	Цахим хаягаар өндөр хүүтэй зээл олгох	1	-	-	1	4.16%	-	-	-	-	0.0%
7	Барьцааг эргүүлэн өгөхгүй байх	3	-	-	3	12.5%	11	1	-	12	39%
	Нийт	18	4	2	24	100%	26	4	1	31	100%

Бусад салбар

Хүснэгт 8. Бусад салбарын өргөдлийн товч утга

№	Төрөл	2024 он				2025 оны хагас жил			
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт
1	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар	19	-	-	19	7	-	-	7
2	Үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн салбар	2	-	-	2	-	-	-	-
3	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбар	4	17	4	25	-	6	3	9
	Нийт	25	17	4	46	7	6	3	16

Хүснэгт 9. Бусад өргөдлийн товч утга

№	Төрөл	2024 он				2025 оны хагас жил			
		Бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Бичиг	Цахим	11-11 төв	Нийт
1	Хорооны хяналттай холбоотой	6	-	-	6	1	-	-	1
2	Зохицуулалтын бус	8	-	-	8	-	-	-	-
3	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх	1	-	-	1	-	-	-	-

2024-2025 оны өргөдөл, гомдлын судалгааны тайлан

4	Лавлагаа, хүсэлт, хуулбар гаргуулах	7	2	-	9	27	1	2	30
	Нийт	22	2	-	24	28	1	2	31

ХОЁР. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

1. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах чиглэлээр цахим мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй зар сурталчилгаанд хяналт тавих чиг үүргийн дагуу цахим хуудсаар гарч буй мэдээлэлтэй танилцаж, зөрчил гаргасан байж болзошгүй болон зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд холбогдуулан хууль тогтоомжийн дагуу тухай бүр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.
2. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчид болон аливаа шалтгааны улмаас биечлэн ирэх боломжгүй иргэд, олон нийтэд зориулж Хорооны албан ёсны цахим хаяг (info@frc.mn)-аар дамжуулан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэж байна.

--o0o--